

БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний
хэрэгжилт, үр дүн

АУДИТЫН КОД: БУА-2026/108-04/ШТА-НА

БУЛГАН АЙМАГ

2026 он

Булган дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор Д.Батцогт
Утас: 7034-2580 Цахим хаяг: Battsogtdb@audit.gov.mn
Аудитын менежер: Ж.Энхцоодол
Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Анхбаяр
Цахим хаяг: Ankhubayard@audit.gov.mn
Аудитор: Б.Энхтөр
Цахим хаяг: Enkhturb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах

хаягаар авна уу. bulgan@audit.gov.mn

АГУУЛГА	Тайлбар	Хуудасны дугаар
Товчилсон үгийн тайлбар	Товчилсон үгийн тайлбар	2
Бүлэг 1	Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын тухайн жилийн үйл ажиллагааны хөтөлбөрд зарим төсөл, арга хэмжээ тусгагдаагүй байна.	3-7
Бүлэг 2	Эрх шилжүүлсэн зарим хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөв өртгийг нэмэгдүүлж худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.	7-9
Бүлэг 3	Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг ажлын гүйцэтгэлд үндэслэн гэрээнд заасан санхүүжилтийн хуваарийн дагуу санхүүжүүлсэн ч санхүүжилтийг олгоогүй 3 төсөл арга хэмжээ байгаа нь хүлээгдэж байгаа болон иргэдийн санал, гомдолтой мөн төсөв хязгаарласантай холбоотойгоор санхүүжилтийг олгоогүй, 4 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанаас хойш хүлээн авч гэрээг дүгнэсэн байна.	9-16
Дүгнэлт	Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн гаргасан дүгнэлт	16-17
Зөвлөмж	Аудитын дүнд үндэслэн зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэх албан тушаалтнуудад өгч буй зөвлөмж	18-18

Товчилсон үгийн тайлбар

ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
ЗГ	Засгийн газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
МСҮТ	Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ТАХ	Төсөл арга хэмжээ
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үнэлгээ
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
НА	Нийцлийн аудит
ШТА	Шууд тайлагнах аудит

**Аудит хийх
үндэслэл, бүрэн
эрх**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дах хэсэгт заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2025 оны 25 дугаар тогтоол, МУЕА-ын 2025 оны А/174 тушаалд тусгасны дагуу уг аудитыг хийж гүйцэтгэнэ.

**Аудитын зорилго,
зорилтууд**

Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулан дүнг аймгийн Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдэнэ. Уг зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг оновчтой төлөвлөсөн эсэх;
- Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулж хяналт тавьсан эсэх;
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хугацаанд нь гүйцэтгүүлж төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх.

**Аудитын хамарсан
хүрээ**

Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлсэн Төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн харьяа байгууллагууд, холбогдох бусад байгууллага, гүйцэтгэгч аж ахуйн нэгжийг хамруулан төсөл, арга хэмжээний төлөвлөлт, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, магадлалын ерөнхий дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг хамруулан аудитыг хийж гүйцэтгэсэн.

БҮЛЭГ 1.

1.1. Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын тухайн жилийн үйл ажиллагааны хөтөлбөрт зарим төсөл, арга хэмжээ тусгагдаагүй байна.

Булган аймгийн ИТХ-ын 2024 оны IV/26 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар 2025 онд он дамжин хэрэгжиж байгаа 6, шинээр хэрэгжих 30 нийт 7,142.8 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий төсөл арга хэмжээг 6,259.97 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр, IV/26 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар шилжих их засвар 4, шинээр хэрэгжих их засвар 2 нийт 990.7 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий төсөл арга хэмжээг 685.7 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталжээ.

Анх баталсан төсөвт өөрчлөлт оруулж Аймгийн ИТХ-ын 2025 оны X/74 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар өмнөх оноос шилжих хөрөнгө оруулалт 6 төсөл, арга хэмжээнд 651.3 сая, шинээр хэрэгжүүлэх 14 төсөл, арга хэмжээнд 2,783.4 сая, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн 13 төсөл, арга хэмжээнд 1,822.5 сая, нийт 5,257.2 сая төгрөгөөр 2025 онд санхүүжүүлэхээр баталжээ. Аймгийн ИТХ-ын 2025 оны X/74 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар өмнөх оноос шилжих их засварын 4 төсөл, арга хэмжээнд 341.0 сая, шинээр хэрэгжих их засварын 2 төсөл арга хэмжээнд 669.3 сая төгрөгийн тус тус баталжээ.

Нийт санхүүжилтийн 57.96 хувийг барилга, байгууламж, 30.75 хувийг тоног төхөөрөмж, 11.29 хувийг их засварын төсөл, арга хэмжээнд тус тус зарцуулахаар төлөвлөжээ.

Шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний 66.7 хувь нь дунд болон богино хугацааны хөгжлийн төлөвлөлтийн баримт бичигтэй нийцсэн байна.

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.5.¹ дах заалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5, 6 дугаар зүйлүүдийн холбогдох заалтуудад хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын тухайн жилийн үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулж төлөвлөхөөр заажээ.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх 39 төсөл, арга хэмжээний 33.3 хувь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын тухайн жилийн үйл ажиллагааны хөтөлбөртэй нийцээгүй байна. Тухайлбал:

Хүснэгт №1

/сая. төгрөгөөр/

№	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Төсөл, арга хэмжээний ангилал	Төсөвт өртөг	2025 онд санхүүжүүлэх дүн
1	Сумын ЗДТГ-ын барилгын засвар (Гурванбулаг сум)	Их засвар	116.47	116.47
2	Төрийн албан хаагчийн орон сууцны барилгын засварын цахилгаан хангамжийн нэмэлт ажил (Баяннуур сум)	Авто зам, дэд бүтэц	36.0	36.0
3	Аймгийн Засаг даргын тамгын газрын лифтний тоноглол, засвар	Тоног төхөөрөмж	70.0	70.0
4	Лейд дэлгэц худалдаж авах (Баян-агт сум)	Тоног төхөөрөмж	39.5	39.5

¹ тухайн жилийн төсвийн хязгаарт багтсан, хөгжлийн бодлогын зорилтуудтай уялдсан байх.

5	Булган аймаг дахь Тагнуулын хэлтсийн алба хаагчдын орон сууцны төлбөр (2 ш орон сууц, 49.67 м2, 58.87м2)	Барилга байгууламж	325.5	325.5
6	Төрийн албан хаагчийн 4 айлын орон сууц худалдан авах (Баян-агт сум)	Барилга байгууламж	99.5	99.5
7	Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албаны автомашин	Тоног төхөөрөмж	289.34	289.34
8	Аймгийн Засаг даргын тамгын газрын албан хэрэгцээний автомашин	Тоног төхөөрөмж	200.00	200.00
9	Сумын Засаг даргын тамгын газрын албан хэрэгцээний автомашин (Гурванбулаг сум)	Тоног төхөөрөмж	180.00	180.00
10	Сумын Засаг даргын тамгын газрын албан хэрэгцээний автомашин (Бугат сум)	Тоног төхөөрөмж	180.00	180.00
11	Сумын Засаг даргын тамгын газрын албан хэрэгцээний автомашин (Тэшиг сум)	Тоног төхөөрөмж	90.00	90.00
12	Сумын Засаг даргын тамгын газрын албан хэрэгцээний автомашин (Бүрэгхангай сум)	Тоног төхөөрөмж	90.00	90.00
13	Төрийн албаны Булган аймаг дахь салбар зөвлөлийн техник, тоног төхөөрөмж	Тоног төхөөрөмж	47.98	47.98
	Нийт дүн		1,764.29	1,764.29

Энэ нь цаашид хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ нь богино болон, урт хугацаанд үр дүн, үр өгөөж өгөх төсөл арга хэмжээ төлөвлөгдөхгүй байх эрсдэлтэй байгаад анхаарах шаардлагатай байна.

Аймгийн хөрөнгө оруулалтаар “Түр амрах цэг шинээр байгуулах (Булган сум)” 68.5 сая төгрөгийн төсөл арга хэмжээг батласан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3-д “Улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно”, 13.3.1-д “Хөшөө, дурсгал, орон нутгийн угтах, үдэх хаалга барьж байгуулах” гэсэн заалтыг зөрчиж байна.

1.2. Хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээг аргачлалын дагуу үнэлж эрэмбэлэн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцож төлөвлөөгүй төсөл арга, хэмжээг төсөв хэлэлцэх явцад нэмж тусган баталсан байна.

МУ-ын Засгийн газрын 2023 оны 278 тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах” журмын 2.3.2.1²-д шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төсөл арга хэмжээг тусгай шалгуур үзүүлэлтийн дагуу судлан шинжилж, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, төслийн бэлэн байдлаар нь эрэмбэлэхийг заажээ.

Аймгийн Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэхээр батлагдсан 39 төсөл, арга хэмжээний 20.5 хувь нь буюу 8 нь эрэмбэлж үнэлээгүй 1,176.8 сая төгрөгийн төсөл, арга хэмжээ байна. Тухайлбал:

² орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөөг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний холбогдох маягт, ангиалалтай ижил байдлаар хэрэгжүүлж, тайлагнах;

№	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Төсөвт өртөг
1	Төрийн албан хаагчийн 4 айлын орон сууц худалдан авах (Баян-агт сум)	99.5
2	Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албаны автомашин	289.34
3	Аймгийн Засаг даргын тамгын газрын албан хэрэгцээний автомашин	200.00
4	Сумын Засаг даргын тамгын газрын албан хэрэгцээний автомашин (Гурванбулаг сум)	180.00
5	Сумын Засаг даргын тамгын газрын албан хэрэгцээний автомашин (Бугат сум)	180.00
6	Сумын Засаг даргын тамгын газрын албан хэрэгцээний автомашин (Тэшиг сум)	90.00
7	Сумын Засаг даргын тамгын газрын албан хэрэгцээний автомашин (Бүрэгхангай сум)	90.00
8	Төрийн албаны Булган аймаг дахь салбар зөвлөлийн техник, тоног төхөөрөмж	47.98
	Нийт дүн	1,176.8

Орон нутгийн хэрэгцээ шаардлагыг эрэмбэлж тооцоо судалгаа хийгдээгүй, журмын шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээ батлагдах нь төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулах эрсдэлтэй байна.

Иймд аймгийн төсвийн Ерөнхийлөн захирагч төсөл, арга хэмжээний саналыг хүргүүлэхдээ “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх, төсөл арга хэмжээг үнэлж эрэмбэлэх үйл ажиллагаа журам”-ын холбогдох заалтуудыг мөрдөж ажиллах шаардлагатай байна.

1.3. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хуульд заасан техник, эдийн засгийн үндэслэл, батлагдсан зураг төсвийн шаардлага хангагдаагүй 3 төсөл, арга хэмжээг тусгасан байна.

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3³, 29.4⁴, 29/1 дүгээр зүйлийн 29/1.1, 29/1.2, Барилгын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.11⁵ дэх заалтууд, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-д шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсөвлөлтийн шаардлагыг тусгажээ.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн шинээр хэрэгжүүлэх барилга, байгууламж барих, их засвар, тоног төхөөрөмж нийлүүлэх 1 төсөл, арга хэмжээ нь зураг, төсөвгүй, 3 төсөл арга хэмжээ нь магадлалын ерөнхий дүгнэлтгүй, зарим тоног төхөөрөмж нийлүүлэх, техникийн тодорхойлолт, ажлын даалгаваргүй 1 төсөл арга хэмжээг төлөвлөсөн байна. /Судалгааны маягт/

Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 -т заасны дагуу техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвийг батлуулсан байх шаардлагыг хангаагүй төсөл, арга хэмжээг ИТХ-аар баталдаг, батлагдсанаас хойш техник эдийн засгийн үндэслэл, зураг төсвийг боловсруулдаг нийтлэг зөрчил давтагдан гарч байна.

³ Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны Засаг дарга, хот, тосгоны Захирагч хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт саналыг дараах байдлаар жилийн төсвийн төсөлд тусгана ...,

⁴ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана

⁵ зураг төсөлгүй барилга байгууламжийг улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулахгүй байх;

Дээрх зөрчлүүд жил бүрийн аудитаар илэрч гарч байгаа нь төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг алдагдуулж, төсвийн төлөвлөлтийн зарчим хангагдахгүй байгааг харуулж байна.

БҮЛЭГ 2. Эрх шилжүүлсэн зарим хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг нэмэгдүүлж худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

2.1. Аймгийн худалдан авах ажиллагааны газар нь ТБОНӨХБАҮХАТХ -ийн 44.4⁶, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журмын 3.2-д⁷ заасны дагуу худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг нэгтгэн баталгаажуулан цахим системд нийтэлжээ.

ТБОНӨХБАҮХАТХ-ийн 9.1⁸, 31.1⁹ -д заасны дагуу нээлттэй болон, харьцуулалтын аргаар худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа ил тод байдлыг хангаж цахим системээр зохион байгуулсан байна.

Төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтын аргын тоон мэдээлэл

/Хүснэгт №3/

/сая. төгрөг/

№	Төсөл арга хэмжээний тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тендер шалгаруулалтын арга						
				Нээлттэй тендер шалгаруулалт		Харьцуулалтын арга		Гэрээ шууд байгуулах		Нэг эх үүсвэрээс худалдан авах
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төсөл арга хэмжээний ангилал	21	5,159.4	4,459.67	12	3,924.44	9	535.23			

Эх сурвалж : ХААГ-аас ирүүлсэн судалгаанаас

Аймгийн Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны 57.1 хувийг нээлттэй тендер шалгаруулалтаар, 42.9 хувийг харьцуулалтын аргаар худалдан авах аргаар тус тус зохион байгуулж 3 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаа амжилтгүй болсон байна. /Судалгааны хүснэгт/

Төсвийн Ерөнхийлөн захирагч орон нутгийн төсвийн хөрөнгөөр нийт 747.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр эрх шилжүүлснээс 1 төсөл арга хэмжээг өөрийн харьяаны бус байгууллагуудад шилжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 14.4¹⁰-д заасантай бүрэн нийцээгүй байна. /Дэлгэрэнгүйг хүснэгтээс харах/

⁶ Төсвийн ерөнхийлөн захирагч тухайн жилийн санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш нэг сарын дотор харьяа захиалагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг нэгтгэн хянаж, баталгаажуулан цахим системд нийтэлнэ”

⁷ Захиалагч тухайн жилийн төлөвлөгөөг батлагдсан нийт төсөвт үндэслэн төсөл, арга хэмжээ нэг бүрээр энэ журмын хавсралтын маягт 1-ийн дагуу боловсруулж, түүнд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ, хүчин чадал, төсөвт өртөг, худалдан авах ажиллагаанд мөрдөх журам, арга, хэрэгжүүлэх хугацаа болон холбогдох тайлбар, тодруулга зэрэг мэдээллийг тодорхой тусгана.

⁸ .Хуульд өөрөөр заагаагүй бол худалдан авах ажиллагааг зохион байгуулах, мэдээлэл солилцох, мэдээллийн ил тод байдлыг хангах ажиллагааг цахим системээр гүйцэтгэнэ.

⁹ 31.1.Захиалагч ерөнхий гэрээний аргаар худалдан авахаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын дараах аргын аль нэгийн дагуу зохион байгуулна:

¹⁰ 14.4.-д “Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсөв хуваарилах, зарцуулахтай холбогдсон бүрэн эрхээ төсвийн төвлөрүүлэн захирагч, эсхүл харьяалах төсвийн шууд захирагчид шилжүүлж болох бөгөөд ийнхүү шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.”

Эрх шилжүүлсэн ТАХ-ний мэдээлэл

Хүснэгт №4

/сая.төгрөгөөр/

№	Эрх шилжсэн төсөв захирагчийн ангилал		Төсөл арга хэмжээний нэр, хүчин чадал байршил	Батлагдсан төсөвт өртөг	Гэрээний дүн	Худалдан авах ажиллагаанд мөрдөгдсөн журам
	Нэр	Ангилал				
1	Булган, Баян-Агт	Төсвийн төвлөрүүлэн захирагч	Төрийн албан хаагчийн 4 айлын орон сууц худалдан авах (Баян-Агт сум)	99.50	99.50	ХА
2	Булган, Гурванбулаг	Төсвийн төвлөрүүлэн захирагч	Сумын Засаг даргын Тамгын газрын албан хэрэгцээний автомашин (Гурванбулаг сум)	180.00	180.00	НТШ
3	Булган, Бугат	Төсвийн төвлөрүүлэн захирагч	Сумын Засаг даргын Тамгын газрын албан хэрэгцээний автомашин (Бугат сум)	180.00	198.55	НТШ
4	Булган, Тэшиг	Төсвийн төвлөрүүлэн захирагч	Сумын Засаг даргын Тамгын газрын албан хэрэгцээний автомашин (Тэшиг сум)	90.00	120.00	ХА
5	Булган, Бүрэгхангай	Төсвийн төвлөрүүлэн захирагч	Сумын Засаг даргын Тамгын газрын албан хэрэгцээний автомашин (Бүрэгхангай сум)	90.00	160.00	ХА
6	Булган, Булган	Төсвийн шууд захирагч	Төрийн албаны Булган аймаг дахь салбар зөвлөлийн техник, тоног төхөөрөмж	47.98	47.98	ХА
7	Булган, Булган	Төсвийн шууд захирагч	Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн засвар, тохижилт	10.00	9.99	ШХА
8	Булган, Тэшиг	Төсвийн шууд захирагч	Хилийн цэргийн 0286 дугаар ангийн ... дугаар заставын алба хаагчдын орон сууц барих (Тэшиг сум)	50.00	50.00	ХА
Нийт дүн				747.48	866.02	

Эх сурвалж : ХААГ-аас ирүүлсэн судалгаанаас

2.2. Аймгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичгийн техникийн тодорхойлолт холбогдох хуулийн заалттай нийцсэн байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах “Үнэлгээний хороо”-г хуульд нийцүүлэн аймгийн Засаг даргын захирамжаар худалдан авах төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан байна.

Сангийн сайдын 2023 оны А/258, А/259, А/260, А/261 дүгээр “Тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг шинэчлэн батлах тухай” тушаалуудыг үндэслэн тендерийн баримт бичгийг боловсруулахаар зохицуулсан байдаг.

Сумын Засаг даргын Тамгын газрын албан хэрэгцээний автомашин (Бугат сум) 19.55 сая төгрөгөөр нэмэгдүүлж 198.55 сая төгрөг, Сумын Засаг даргын Тамгын газрын албан хэрэгцээний автомашин (Тэшиг сум) 30.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 120.0 сая төгрөг, сумын Засаг даргын Тамгын газрын албан хэрэгцээний автомашин (Бүрэгхангай сум) 50,0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 150,0 сая төгрөг зохион байгуулсан байна.

Эдгээр төсөл арга хэмжээний техникийн тодорхойлолтыг төсөв батлагдсанаас хойш хийсэн нь ТБОНӨХБАҮХАТХ 12.3¹¹ 12.4¹², 12.5¹³-д заалттай нийцээгүй байна.

Энэ нь бараа бүтээгдэхүүнийг нийлүүлэгч чанаргүй бараа бүтээгдэхүүн нийлүүлэх, үүнтэй холбоотойгоор нэмэлт засвар үйлчилгээний зардал гарах, гомдол маргаан үүсэх эрсдэлтэй байна.


2.3 Холбогдох хууль, журам, тендерийн баримт бичигт тусгасан шаардлагыг хангасан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна.

ТБОНӨХБАҮХАТ хууль, Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм”, 2023 оны 278 тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-д нийцүүлэн тендерийн баримт бичигт тусгагдсан шаардлагыг хангасан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан байна.

БҮЛЭГ 3. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг ажлын гүйцэтгэлд үндэслэн гэрээнд заасан санхүүжилтийн хуваарийн дагуу санхүүжүүлсэн ч санхүүжилтийг олгоогүй 3 төсөл арга хэмжээ байгаа нь хүлээгдэж байгаа болон иргэдийн санал, гомдолтой мөн төсөв хязгаарласантай холбоотойгоор санхүүжилтийг олгоогүй байна.

3.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг ажлын гүйцэтгэлд үндэслэн хууль журмын дагуу санхүүжүүлсэн ч санхүүжилтийг олгоогүй 3 төсөл арга хэмжээ байгаа нь хүлээгдэж байгаа болон иргэдийн санал, гомдолтой мөн төсөв хязгаарласантай холбоотойгоор санхүүжилтийг олгоогүй шалтгаантай байна.

Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн Х/74 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулж 7,114.3 сая төгрөгийн өртөгтэй 39 төсөл, арга хэмжээ болгон баталж тогтоолоор 1,207.4 сая төгрөгийн өртөгтэй 10 төсөл, арга хэмжээн өмнөх оноос шилжиж ирснээс их засварын 328.3 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээ байгаа бол шинээр хэрэгжсэн 5,906.9 сая төгрөгийн өртөгтэй 29 төсөл, арга хэмжээнээс их засварын 646.0 сая төгрөгийн өртөгтэй 2 их засварын ажил хэрэгжсэн байна.



¹¹ Хүүхэд хамгааллын тухай хуулийн 30.4-т заасан хүүхэд хамгааллын бодлого батлаагүй хуулийн этгээд,

¹² Техникийн тодорхойлолтод тодорхой нэг аж ахуй эрхлэгчийн бараа, үйлчилгээний худалдааны нэр, патент, түүнийг эзэмшигч, үйлдвэрлэгч, нийлүүлэгч, эсхүл үйлдвэрлэлийн арга, гарал үүслийг тухайлан заахыг хориглоно.

¹³ Техникийн тодорхойлолтыг нарийвчлан тодорхойлох боломжгүй бол энэ тухай үндэслэл бүхий тайлбарыг дурдсаны үндсэн дээр зөвхөн тухайн бараанд холбогдуулан энэ хуулийн 12.4-т заасан шаардлага, нөхцөлийг тавьж болох бөгөөд энэ тохиолдолд "эсхүл түүнтэй дүйцэх" гэсэн тодотгол хэрэглэнэ.

ОНХО-аар олгосон санхүүжилтийн мэдээллийг хүснэгтээр харуулбал

/Хүснэгт №5/

/сая.төгрөг/

Төсөл арга хэмжээний ангилал	АИТХ-ын 2024.12.25-ны 4/26			АИТХ-ын 2025.08.22-ны Х/74 тогтоол /тодотголоор/					
	АХ тоо	Төсөвт өртөг	Баталсан санхүүжилт	ТАХ тоо	Төсөвт өртөг	Баталсан санхүүжилт	Гэрээний дүн	Санхүүжсэн дүн	Үлдэгдэл санхүүжилт
Авто зам, дэд бүтэц	16	2,850.00	2,850.00	15	2,487.12	2,487.12	2,482.89	1,921.3	29.68
Барилга байгууламж	7	2,374.80	1,491.90	4	1,730	847.15	847.09	540.97	
Их засвар, тохижилт	4	808.70	503.70	4	805.17	500.17	737.82	425.63	68.7
Тоног төхөөрөмж	15	2,100.00	2,100.00	14	1,922.01	1,922.01	1,986.64	1,822.82	59.85
Бусад	0	0	0	2	170	170	168.15	159.8	
Нийт дүн	42	8,133.50	6,945.6	39	7,114.3	5926.45	6,222.59	4,870.52	158.23

Тухай онд хэрэгжсэн төсөл арга хэмжээний ажил гүйцэтгэх гэрээгээр нийт 39 төсөл, арга хэмжээний 6,222.6 сая төгрөг, гүйцэтгэлээр нийт 4,870.52 сая төгрөгийн 36 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг олгосон байна. Үүнээс санхүүжилтийг олгоогүй 3 төсөл арга хэмжээ байгаа нь хүлээгдэж байгаа болон иргэдийн санал гомдолтой мөн төсөв хязгаарласантай холбоотойгоор санхүүжилтийг олгоогүй шалтгаантай байна.

Төсөл, арга хэмжээний эхний болон явцын санхүүжилтийг олгохдоо хяналт хэрэгжүүлсэн эрх бүхий албан тушаалтнуудын баталгаажуулсан ажлын гүйцэтгэл, ашиглагч байгууллагын тодорхойлолт, гүйцэтгэгчийн хүсэлтийг үндэслэн гэрээний тусгай нөхцөлд заасны дагуу 30.0-80.0 хувиар тооцож, гүйцэтгэгч компаниудад олгосон байна.

Булган аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн XXIV/05 дугаар тогтоол “Чанарын баталгааны барьцаа хөрөнгө чөлөөлөх тухай”-ын үндэслэж 61.84 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын барьцаа дансанд байршуулсан бол үүнээс 15.7 сая төгрөгийн барьцаа хөрөнгийг цуцалж, 46.14 сая төгрөгийн барьцаа хөрөнгийг цуцлаагүй байна.

Гэрээний хугацаа хэтрүүлсэн "Цаст Цант Бүтээмж хоршоо"-ны бэлтгэсэн Аймгийн өвсний нөөц бүрдүүлэлт, "Бизхаус" ХХК-н нийлүүлсэн Бүрэгхангай сумын Засаг даргын тамгын газрын албан хэрэгцээний автомашин 2 төсөл арга хэмжээ байсныг захиалагч талаас нийт 940.0 мянган төгрөгийн алданги тооцож авсан байна.

Санхүүжилтийг олгоогүй төсөл арга хэмжээг хүснэгтээр харуулбал

/Хүснэгт №6/

/сая.төгрөг/

№	Аймаг, сумын нэр	Төсөл, арга хэмжээний нэр	Гэрээний дүн	Гүйцэтгэгчийн нэр
1	Булган, Дашинчилэн	Ерөнхий боловсролын сургуулийн сантехникийн засвар	29.68	"Жэй Эм Жи Юү" ХХК
2	Булган, Булган	МСҮТ-ийн барилгын засварын орон нутгийн оролцооны хөрөнгө	13.36	"Хурмастын хүлэг" ХХК

3	Булган, Сэлэнгэ	Цахим сүлжээ сайжруулах гурвалсан үйлчилгээ нэвтрүүлэх	59.85	"Эм Ти Си Сервис" ХХК
	Дүн		102.89	

**Сэлэнгэ сумын цахим сүлжээ сайжруулах гурвалсан үйлчилгээний
төхөөрөмж**



**Иргэдийн санал гомдлын дагуу үйлчилгээ авсан өрхөд хяналт хийсэн
байдал**



**Гурвалсан үйлчилгээнд холбогдсон төсвийн байгууллагын үзүүлэлтийг
харуулбал:**

№	Төрийн байгууллага	Хурд	Тайлбар
1	Зэд-Хантай БНДЦГХЗахиргаа	12 mbps	МЦХ
2	Ерөнхий боловсролын сургууль	355.62 mbps	unitel
3	Хүүхдийн цэцэрлэг	5.8-7.7mbps	МЦХ
4	Эрүүл мэндийн төв	3.7 mbps	МЦХ
5	Соёлын төв	7.5 mbps	МЦХ
6	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	6.8 mbps	МЦХ
7	Засаг даргын тамгын газар	7.8 mbps	МЦХ
8	Цаг уур	4.6 mbps	mobicom

Тендерийн үйлчилгээний тодорхойлолтод тавигдах шаардлагын 10 дугаар заалтад “Үйлчилгээ үзүүлэгч нь нэг өрхийн интернэтийн хэрэгцээнд зориулж интернэтийн нийт урсгалын хурдыг 10 Мб/сек-ээс багагүй байхаар тооцож сүлжээний зохион байгуулалтыг хийнэ” гэсэн шаардлагыг хангахгүй байна.

Гэрээний хугацаанд хүлээж аваагүй төсөл арга хэмжээний хувьд Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4 дүгээр зүйл¹⁴ байнгын ашиглалтад оруулах комиссын дүгнэлт гүйцэтгэгчийн


¹⁴ 4.3.6.10.байнгын ашиглалтад хүлээн авах комиссын хурлын тэмдэглэл, үүрэг даалгавар, түүний биелэлт; 4.3.6.11.байнгын ашиглалтад хүлээн авсан улсын комиссын акт эх хувь

хүлээлгэн өгөх хүсэлтээс хойно хүлээж авч байгаа шалтгаан тайлбарыг хурлын тэмдэглэлд дурдаагүй, чанарын баталгааг байршуулах банк болон банкны дансыг гэрээнд тусган гэж гэрээнд тавигдах нөхцөл, шаардлагад заасан ч гэрээнд тусгаагүй байна.

Булган сумын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн нийт 49 төсөл арга хэмжээг 2025 онд 1,587.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөж гүйцэтгэлээр 1,146.9 сая төгрөгийн 40 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.

3.2 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийг гэрээнд заасан төлөвлөсөн хугацаанд хүлээлгэж өгсөн ч төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанаас хойш хүлээж авч гэрээг дүгнэсэн байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 7,114.35 сая төгрөгийн өртөгтэй 39 төсөл, арга хэмжээг баталсан байна.



Үүнээс өмнөх оноос дамжиж ирсэн болон шинээр хэрэгжиж байгаа 4,749.3 сая төгрөгийн өртөгтэй 36 төсөл, арга хэмжээний гэрээг дүгнэж, гэрээний хугацаанд хүлээлгэж өгсөн бол 2,365.0 сая төгрөгийн өртөгтэй 3 төсөл арга хэмжээний гэрээний хүлээлгэн өгөх хугацаа дуусаагүй, гүйцэтгэл дутуу байгаа тул гэрээг дүгнэж хүлээж аваагүй байна.

3.3 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг, техникийн тодорхойлолтын дагуу гүйцэтгүүлж, холбогдох хууль журамд нийцүүлэн хүлээн авсан ч Сэлэнгэ сумын Цахим сүлжээ сайжруулах гурвалсан үйлчилгээний хэрэгжилт хангалтгүй, тавигдах шаардлагад нийцээгүй байна.



Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2025 онд албан хэрэгцээнд 6 авто машин, 4 механизм 16 ширхэг суурин компьютер, эрүүл мэндийн төвд 3 төрлийн тоног, төхөөрөмж, айл өрхийн хэрэгцээний гурвансан үйлчилгээний сүлжээг сайжруулах тоног төхөөрөмж авах зэрэг худалдан авах ажиллагаа зохион байгуулж техникийн тодорхойлолтын дагуу хүлээж авсан байна.

Үүнээс Сэлэнгэ сумын Цахим сүлжээ сайжруулах гурвалсан үйлчилгээ нэвтрүүлэх 60.0 сая төгрөгийн өртөгтэй төсөл, арга

хэмжээг ашиглалтад оруулсан боловч захиалагч талын тавигдах шаардлагыг хангахгүй байна.

Үүнд:

- Сүлжээг найдвартай ажиллуулах, гарсан гэмтэл саатлыг тухайн бүрд хурдан шуурхай хяналтын хугацаанд чанартай засварлах, сүлжээний аль ч түвшинд асуудал гарвал нэн даруй шийдэх чадамжтай боловсон хүчний нөөцтэй байх ба тухайн суманд 3 доошгүй жил ажилласан байх,

- Сүлжээний ашиглалт, ажиллагааны байдлыг 24 цагаар хянах сүлжээ удирдлагын төвтэй, тогтвортой ажиллагааны түвшнийг хангасан байх,
- Үйлчилгээ үзүүлэгч нь интернэтийн болон гурвалсан үйлчилгээг хүргэхэд шаардлагатай өөрсдийн үндсэн тоног төхөөрөмжүүдээс гадна нэмэлт төхөөрөмж техник хэрэгслийг нийлүүлэх. Хэрэв үйлчилгээ үзүүлэгчээс интернэтийн болон гурвалсан үйлчилгээ хүргэхэд нэмэлт тоног төхөөрөмж, хэрэгсэл шаардлагатай бол жагсаалтыг ирүүлнэ,
- Сүлжээний ачааллын багтаамж нь үүрэгт үйлчилгээг үзүүлэхэд хангахуйц байна. (эцсийн хэрэглэгчид шаардагдах сүлжээний урсгалын хурдыг тооцсон тооцооллыг ирүүлэх)
- Үйлчилгээ үзүүлэгч нь сүлжээний ашиглалт, интернэт урсгалын хэвийн ажиллагааны байдлыг хянах сүлжээ удирдлагын төвтэй, тогтвортой ажиллагааны түвшнийг хангасан байх,
- Үйлчилгээ үзүүлэгч нь нэг өрхийн интернэтийн хэрэгцээнд зориулж интернэтийн нийт урсгалын хурдыг 10 Мб/сек-ээс багагүй байхаар тооцож сүлжээний зохион байгуулалтыг хийнэ,

Гурвалсан үйлчилгээнд 100 гаруй өрх холбогдсон ч хэрэгцээ шаардлагад нийцэхгүй байгаагаас айл өрхүүд гэрээгээ цуцалж, гомдол саналаа нутгийн удирдлагуудад гаргасан байна.

3.4 Хэрэгжиж дууссан төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийг бүртгэлд тусгаагүй 8 төсөл, арга хэмжээ байгаа ч зориулалтын дагуу ашиглаж байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 39 төсөл арга хэмжээнд 6,222.59 сая төгрөгийг баталж, хэрэгжүүлснээс 2,365.0 сая төгрөгийн өртөгтэй 3 төсөл арга хэмжээ гэрээний хугацаа дуусаагүй он дамнасан, гүйцэтгэл нь 25, 90 хувьтай хэрэгжиж байгаа бол 831.68 сая төгрөгийн 5 төсөл арга хэмжээ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас гарах данс бүртгэлд бүртгэх шийдвэрийг хүлээж байна. 7,114.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 39 төсөл, арга хэмжээ байгаагаас 31 төсөл, арга хэмжээний 5,508.9 сая төгрөгийн хөрөнгийг холбогдох байгууллагууд Орон нутгийн өмчийн газрын шийдвэрийн дагуу бүртгэлд тусгажээ.

Булган сумын 81.0 сая төгрөгийн өртөгтэй 4 төсөл арга хэмжээ бүрэн дууссан ч бүртгэлд тусгаагүй байна.

Данс бүртгэлд тусгаагүй хөрөнгийг хүснэгтээр харуулбал

/Хүснэгт №7/

/сая.төгрөг/

№	Төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Бүртгэлд тусгаагүй дүн	Тайлбар
1	Сумын төвийн хатуу хучилттай авто зам барих ажлын үргэлжлэл (Тэшиг сум)	298.94	298.94	Бүртгэлд тусгаагүй
2	Суурьшлын бүсийн цахилгаан хангамж (Хишиг-Өндөр сум)	166.84	166.84	Бүртгэлд тусгаагүй
3	Шинэ суурьшлын бүсэд цахилгааны эх үүсвэр татах (Рашаант сум, Нарлаг хороолол)	160.70	160.70	Бүртгэлд тусгаагүй
4	Шинэ суурьшлын бүсэд цахилгааны эх үүсвэр татах (Хишиг-Өндөр сум)	145.35	145.35	Бүртгэлд тусгаагүй
5	Цахим сүлжээ сайжруулах гурвалсан үйлчилгээ нэвтрүүлэх (Сэлэнгэ сум)	59.85	59.85	Бүртгэлд тусгаагүй
6	17 дугаар байрны дээвэр хэсэгчилж засварлах /Булган сум/	19.0	19.0	Бүртгэлд тусгаагүй

7	Хойд тойргийн замд хурд сааруулагч тэмдэг тэмдэглэгээ хийх /Булган сум/	20.0	20.0	Бүртгэлд тусгаагүй
8	5-р багийн үерийн далангийн засварын ажлын зураг төсөв /1-р сургуулийн уулзвараас доод 4 зам хүртэл/ /Булган сум/	15.0	15.0	Бүртгэлд тусгаагүй
9	Хорооллын замын нөхөөс /багууд/ /Булган сум/	27.0	27.0	Бүртгэлд тусгаагүй
Нийт		912.68	912.68	

Хэрэгжиж дуусаагүй төсөл, арга хэмжээг хүснэгтээр харуулбал

/Хүснэгт №8/

/сая.төгрөг/

№	Төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Бүртгэлд тусгаагүй дүн	Тайлбар
1	Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар (Хангал сум)	610.0	305.00	Хэрэгжиж байгаа
2	Сумын төвийн автозамын үргэлжлэл (Рашаант сум)	500.0	500.00	Бүртгэлд тусгаагүй /95 хувь/
3	Биеийн тамирын заалны барилга (Могод сум)	1255.0	600.00	Хэрэгжиж байгаа
Нийт		2,365.0	1,405.0	

Булган сумын Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжээгүй ТАХ-г хүснэгтээр харуулбал

/Хүснэгт №9/

/сая.төгрөг/

№	Төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Тайлбар
1	104-р байрны зогсоолын өргөтгөл /ШШГ Газрын байр/	10.0	Хэрэгжээгүй
2	2-р багийн зураг төсөв /далангийн зураг/	19.0	Хэрэгжээгүй
3	ШШГ Байрны хажуу талын зогсоол	10.0	Хэрэгжээгүй
4	1-р багийн бунхны арын үерийн шуудуу зураг төсөв	10.0	Хэрэгжээгүй
5	1-р сургуулийн заалны шал таазны засвар /бага сургууль/	50.0	Хэрэгжээгүй
6	3-р сургуулийн зогсоолын үргэлжлэл	60.0	Хэрэгжээгүй
7	104-р байрны зогсоолын үргэлжлэл /цагдаагийн 1-р байр/	76.0	Хэрэгжээгүй
8	Сайхан уул байрны гадна талын зогсоол	40.0	Хэрэгжээгүй
9	Залуус хорооллын шугамын ажил /нэмэлтээр/	65.0	Хэрэгжээгүй
Нийт		340.0	

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих 340.0 сая төгрөгийн 9 төсөл арга хэмжээ нь төсөв хязгаарлагдсан шалтгаанаар тендер зарлагдаж амжаагүй, хэрэгжээгүй байна.

Дүгнэлт:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын тухайн жилийн үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдаагүй 13 төсөл, арга хэмжээ,

шинээр хэрэгжүүлэхээр батлагдсан 39 төсөл, арга хэмжээний 8 төсөл арга хэмжээ нь эрэмбэлж үнэлээгүй аймгийн орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаар баталсан байна.

- Аймгийн ИТХ-ын хэлэлцүүлгийн явцад өөрчлөн баталж буй нь хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хэрэгжих ажлын цар хүрээ, хийгдэх ажлын тоо хэмжээ тодорхой бусаас санхүүжилт дутагдах, үргүй зардал гаргах, тухайн төсөл арга хэмжээ хугацаандаа хийгдэхгүй байх, дахин санхүүжилт шаардлагатай болох эрсдэлтэй байгаад анхаарч холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хөрөнгө оруулалтыг төлөвлөх шаардлагатай байна.
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журмын 3.2-д¹⁵ заасны дагуу худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг нэгтгэн баталгаажуулан цахим системд нийтлэж, нээлттэй болон, харьцуулалтын аргаар худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа ил тод байдлыг хангаж цахим системээр зохион байгуулсан байна.
- Хөрөнгө оруулалтын төсөв боловсруулахдаа холбогдох хууль, журмын шаардлагад нийцсэн төсөв боловсруулдаггүй, төсөв хэлэлцэх явцад ТЭЗҮ, ажлын даалгавар, техникийн тодорхойлолтгүй төсөл, арга хэмжээг баталдаг нь тухайн төсөл арга хэмжээ хэрэгжилтэд төсөв нэмэгдэх, хугацаа алдах зэрэг эрсдэл үүсдэг. Мөн үр дүн, үр өгөөж, үр нөлөө тодорхой бус хэрэгцээ, хүртээмж нь ойлгомжгүй, ашиглалт, хадгалалт хамгаалалтын асуудал шийдэгдэхгүйгээс төсөв үрэлгэн зарцуулагддаг.
- Төсөл, арга хэмжээг хүлээж авахдаа хугацаа хоцроож авсан тайлбар шалтгааныг хурлын тэмдэглэл дээр тусгаагүй.
- ТЕЗ-ийн харьяаны бус төсвийн шууд захирагчид төсөл, арга хэмжээний эрхийг шилжүүлсэн.
- Төсөл арга хэмжээний үр дүнд бий болсон эд хөрөнгийн байнгын ашиглагчийг бүрэн тодорхойлдоггүй, бүртгэлд тусгах эрх зүйн шийдвэрийг бүрэн гаргадаггүй зэрэг эрсдэлүүд үүсэж байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Ж.Ганболд танаа:

1. Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.42¹⁵ -т заасны дагуу техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвийг батлуулсан байх шаардлагыг хангасан төсөл, арга хэмжээг хэлэлцүүлэн батлах,

Аймгийн Засаг дарга Д.Пүрэв-Очир танаа:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө хууль, эрх зүйн холбогдох шаардлагад нийцүүлэн төлөвлөх, төлөвлөлтөд тавих хяналтыг сайжруулах.

¹⁵ Захиалагч тухайн жилийн төлөвлөгөөг батлагдсан нийт төсөвт үндэслэн төсөл, арга хэмжээ нэг бүрээр энэ журмын хавсралтын маягт 1-ийн дагуу боловсруулж, түүнд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ, хүчин чадал, төсөвт өртөг, худалдан авах ажиллагаанд мөрдөх журам, арга, хэрэгжүүлэх хугацаа болон холбогдох тайлбар, тодруулга зэрэг мэдээллийг тодорхой тусгана.

Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга Б.Ариунболд танаа:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа төсөл арга хэмжээний санхүүжилтийг олгохдоо гэрээнд болон гүйцэтгэсэн ажил, хүлээж авахдаа хяналтыг хэрэгжүүлж санхүүжилтийг олгох.
2. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн санхүүжилт олгохдоо ЗГ-ын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.3-т заасан баримт бичгийн бүрдлийг цаасаар бүрэн бүрдүүлэх.

Аймгийн орон нутгийн өмчийн газрын дарга Т.Баттулга танаа:

1. Төсөл арга хэмжээний үр дүнд бий болсон эд хөрөнгийн байнгын ашиглагчийг бүрэн тодорхойлж, бүртгэлд тусгах эрх зүйн шийдвэрийг бүрэн гаргах, ТАХ-г ашиглагч байгууллагын бүртгэлд тусгуулах.

-oOo-



Булган сум

6326010029

